

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 5/08

Мандалговь

Цар тахлын үед албан хаагчид болон
тэдгээрийн Гэр бүл хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйл, 51 дүгээр зүйлийн 51.2 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/144 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Улс оронд үүсээд байгаа шинэ коронавирус (КОВИД-19)-ын цар тахлын үед байгууллагын албан хаагчид болон тэдгээрийн гэр бүл, хүүхдүүдийг урьдчилан сэргийлэх, дархлааг дэмжих зорилгоор 1,268,700.0 (нэг сая хоёр зуун жаран найман мянга долоон зуун) төгрөгийг зарцуулсугай.

Хоёр. Дэмжлэг үзүүлэх албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

Гурав. Дээрх зардлыг Бусдаар гүйцэтгүүлсэн бараа ажил үйлчилгээний зардлаас гаргахыг нягтлан бодогч (Б.Энхдөл)-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Цар тахлын үед баримтлах халдварт хамгааллын дэглэмийг баримтлан албан хаагчдад тараахыг нярав (П.Мөнхсүх)-д үүрэг болгосугай.



482110 32